

**ХОРИН ХОЁРДУГААР БААЗ ХК
ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 21 өдөр
хот

Дугаар 28/02

Улаанбаатар

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан 7
хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, компанийн тухай хуулийн 62-р зүйлийн 62.2.3 дахь заалт, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдөр батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны ээлжит хурлыг 2023.04.28-ны өдрийн 14:00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг Энхтайвны өргөн чөлөө, өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.
2. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дор дурдсан асуудлыг хэлэлцэхээр баталсугай:
 1. Компанийн 2022 оны үйл ажиллагааны тайланг гүйцэтгэх захирал Т.Зоригтбаатар танилцуулах.
 2. Компанийн 2022 оны санхүүгийн тайланг нягтлан М.Нэргүй танилцуулах.
 3. Компанийн санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
 4. Ногдол ашиг хувиарлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах.
 5. Гарц гаргах тухай.
 6. Дотор дулааны шугамын засварын тухай.
 7. Бусад.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 04-р сарын 14-ний өдрөөр тасалбар болгосугай.
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдөр өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2023 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерийн компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.
5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /З.ТУУЛ/-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.
6. Хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ын агуулгыг хавсралт 2-т зааснаар баталсугай.
8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2023 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 14:00 цагаар тасалбар болгосугай.
9. Тогтоолын хэрэгжилтийг хангах, ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хурал зохион байгуулах бөгөөд тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай:
 - Т.Халиун дарга
 - Н.Мэндсайхан гишүүн
10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р Бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдлийг хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /З.Туул/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ГҮНДЭГМАА